

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН НИЙГМИЙН
ХӨГЖЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
ОРЛОГЧ Ц.ЭНХЦЭНГЭЛ

Д.ЛУВСАНШАРАВЫН НЭРЭМЖИТ ХҮҮХДИЙН НАЙРАЛ
ДУУНЫ ШИЛДЭГ ХАМТЛАГ ШАЛГАРУУЛАХ ХХИ
УДААГИЙН УРАЛДААНТ НААДМЫН УДИРДАМЖ

Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулиудын хөгжмийн хичээлийн сургалтыг чанаржуулж, өсвөр үеийнхэнд уран сайхны боловсрол олгох, гоо зүйн хүмүүжлийг төлөвшүүлэх, хүүхэд бүрийн авьяасыг хөгжүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын ивээл дор уламжлал болон зохиогддог Монгол улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Ардын жүжигчин Дагвын Лувсаншарав агсны нэрэмжит "Хүүхдийн найрал дууны шилдэг хамтлаг" шалгаруулах уралдаант наадмыг зарлаж байна.

Найрал дууны уралдаант наадмын зохион байгуулалт:

Найрал дууны уралдаант наадамд заавал дуулагдах дууны сургалт ЕБС-ийн хөгжмийн багш нарын дунд Сүхбаатар дүүргийн 116-р сургуулийн байранд 09-р сарын 17-ны өдөр явагдана.

Анхан шатны шалгаруулалт:

Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар анхан шатны шалгаруулалтыг 10 дугаар сарын 08, 09, 10-ны өдрүүдэд тусгай хуваарийн дагуу дүүрэгтээ зохион байгуулна. Дүүргүүд уралдааны анхан шатны шалгаруулалтад нутаг дэвсгэрийн бүх сургуулиудыг оролцуулах бөгөөд дүүрэг тус бүр 3 хамтлагийг сонгон шалгаруулж төгсгөлийн шатанд оролцуулна. Шалгарсан хамтлагуудын мэдүүлэг болон анхан шатны шалгаруултын талаар илтгэх хуудсыг Нийслэлийн Соёл урлагийн газарт дүүргүүдийн соёлын асуудал хариуцсан мэргэжилтнүүд 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ.

Хоёрдугаар шатны шалгаруулалт

II шатны шалгаруулалтыг Монголын Хүүхдийн ордонд 10 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулна. Дүүрэг бүрээс эхний 3 байрт шалгарсан найрал дууны хамтлаг II шатны шалгаруулалтанд оролцоно.

II шатны шалгаруулалтанд амжилттай оролцсон сургуулиудын найрал дууны хамтлагийг Нийслэлийн өдрийн хүндэтгэлийн тоглолтод оролцуулах ажлыг тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулна. Хүндэтгэлийн тоглолт "Соёлын төв өргөө"-нд 2014 оны 10-р сарын 29-ны өдөр болно.

Уралдаанд тавигдах шаардлага

Уралдаант наадамд нийт 3 дуугаар оролцоно. Үүнд:

- а/ Заавал дуулах дуу
- б/ Өөрийн урын санд шинээр орсон дан найрал дуу
- в/ Хөгжимтэй найрал дууны бүтээл

Заавал дуулах дууг Уралдааныг Зохион байгуулагчид "Хүүхдийн найрал дуунд зориулсан бүтээлийн уралдаан"-нд шалгарсан бүтээлээс сонгоно. Өөрийн сонголтоор дуулах дан найрал дууг хөгжмийн багш найруулга хийж оролцоно.

- Дуулагдах дуунууд өндөр ур чадвар шаардсан байна.
- Уралдааныг мэргэжлийн эрдэмтэн багш нар, уран бүтээлчид дүгнэнэ.
- Уралдаанд оролцох дуунуудын партитур, нотыг дүүргүүдийн ЗДТГ болон Нийслэлийн Боловсролын газраар дамжуулан нийт сургуулиудад хүргэнэ.

Уралдааны шагнал урамшуулал

Уралдаанд оролцох хамтлаг, багшийг:

1. Дууны сонголт
2. Найруулга
3. Найрал дуучдын болон хормейстр багшийн ур чадвар
4. Тайзны соёл, хувцаслалт
5. Эрэгтэй эмэгтэй хүүхдийн тооны харьцааг шийдвэрлэсэн байдал /Оролцох хамтлаг 60-аас дээш хүний бүрэлдэхүүнтэй байх/
6. Бэлтгэл зохион байгуулалт зэрэг шалгуураар дүгнэж дараах байр эзлүүлэн шагнаж урамшуулна.

Тэргүүн байр	1	Өргөмжлөл	5.000.000 төгрөг
Дэд байр	1	Өргөмжлөл	3.500.000 төгрөг
Гурадугаар байр	1	Өргөмжлөл	2.000.000 төгрөг
Тусгай байр	2	Өргөмжлөл	1.000.000 төгрөг
Шилдэг удирдаач багш 1		Өргөмжлөл	500.000 төгрөг
Шилдэг найралжуулагч багш 1		Өргөмжлөл	500.000 төгрөг

Жич: Уралдаанд хамгийн олон сургууль оролцуулж анхан шатны шалгаруулалтыг өндөр түвшинд зохион байгуулсан дүүргийн соёлын асуудал хариуцсан нэг мэргэжилтэнг шалгаруулж Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

Ерөнхий зохион байгуулагч:

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН СОЁЛ УРЛАГИЙН ГАЗАР

Хамтран зохион байгуулагч:

НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗАР

ДҮҮРГҮҮДИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

НАЙРАЛ ДУУНЫ УРАН БҮТЭЭЛЧДИЙН ХОЛБОО

Хаяг: СБД 7-р хороо, Амарын гудамж,
Соёлын төв өргөө "Г" корпус 503 тоот

Харилцах утас: 324537, 321529, 99013783,

Мэйл хаяг: www.delqermaa.soyol@yahoo.com